

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

МОНГОЛ УЛСЫН ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛИЙГ АШИГЛАХ НЬ: АСУУДАЛ, ШИЙДЭЛ

*Д. Сундуйсүрэн. Удирдлагын академийн
УУПБ-ийн профессор, доктор (Ph.D),
цагдаагийн хурандаа*

*Б.Батчингис. 8022 дугаар дамжааны
магистрант, хошууч*

Түлхүүр үгс. Хорих байгууллага, харуул хамгаалалт, хоригдол, биечилсэн хяналт, техникийн хяналт, техник хэрэгсэл.

Хураангуй: Энэхүү илтгэлээрээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үндсэн чиг үүргийн нэг болох хорих ял эдлүүлэх ажиллагааны харуул хамгаалалтад ашиглагдаж буй техник хэрэгсэл, технологийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй зарим асуудал, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлохыг зорилоо.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь шүүхийн бүх төрлийн шийдвэрийг албадан гүйцэтгэхдээ хууль сахиулах буюу хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэхийн зэрэгцээ иргэн, хоригдол, алба хаагч, түүнчлэн хорих анги, цагдан хорих, баривчлах байр, бусад онцгой объектын аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд хорих ял эдлүүлэх ажиллагаа нь хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах, хоригдлыг нийгэмшүүлэх, хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг тогтмолжуулах гэсэн үндсэн чиглэлүүдэд хуваагдаж байгаа бөгөөд хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах, хүсэл, сонирхолд нь үндэслэн эерэг зан үйлд төлөвшүүлэх

зэрэг зорилтуудын хүрээнд нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна¹.

Ингээд хорих байгууллагын харуул хамгаалалтын талаар товч дурдья. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дахь харуул хамгаалалтын үйл ажиллагаа нь хоригдлуудын байршил, амьдралын болон үйлдвэрлэлийн бүс, ажлын байранд хяналт тавих замаар хорих ялын биелэлтийг хангах, тэдгээрийн хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх таслан зогсоох, түүнчлэн хоригдол болон байгууллага алба хаагчдын аюулгүй байдлыг хангахад чиглэсэн цогц арга хэмжээ юм.

Хорих ангийн харуул хамгаалалтын зорилго, зорилтууд нь өөрийн гэсэн онцлогтой бөгөөд цагдан хорих тухай шүүгчийн шийдвэрийг гүйцэтгэх, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагааг Олон улсын болон Монгол Улсын хууль, тогтоомж, хоригдолтой харьцах стандарт шаардлагад нийцүүлэн гүйцэтгэх нь хорих байгууллагын зорилго гэж үзэж болно.

Харин техникийн талаар товч авч үзвэл грек хэлний “техникос” буюу “техне” /урлаг, гар урлал, ур чадвар/ гэсэн үгнээс гаралтай бөгөөд хүний гараар бүтсэн бүх эд зүйлсийг хамарсан ойлголт² бөгөөд хамгаалах хэрэгсэл нь үйлдвэрийн аюулгүй ажиллагааны ерөнхий техникийн арга хэмжээгээр ажлын аюулгүй ба хортой нөхцөлөөс хангаж чадахгүй бүх тохиолдолд ашигладаг эд зүйлийг хэлнэ.

Хамгаалах техник гэдэг нь үйлдвэрлэлийн хортой нөхцөлд ажиллагсдад нөлөөлөхөөс хамгаалах зорилготой зохион байгуулалт, техникийн арга хэмжээ, хэрэгслийн систем гэж үзэж болно.

Хорих байгууллагын харуул хамгаалалтад ашиглагдаж буй техник хэрэгслийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, түүнд нийцүүлэн баталсан журам, заавар, стандартад хамгаалалтын байгууламж, хамгаалалтын хүч хэрэгсэл, хамгаалалтын техник

¹ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/150 дугаар тушаал батлагдсан “ХЗДХС-ын эрхлэх асуудлын хүрээний агентлаг байгууллагуудын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”

² Википедиа нэвтэрхий толь.

хэрэгсэл гэж ангилан, тэдгээрт ашиглаж буй хэрэгслийн төрөл, нэр, томьёог ийнхүү тусган тайлбарлажээ. Үүнд:

Хамгаалалтын байгууламжид:

- Хорих анги;
- Цагдан хорих байр;
- Хорих байр;
- Хорих өрөөний хаалга, цонхны төмөр сараалжин хаалт;
- Хэрмэн хашаа, үндсэн хашаа;
- Хяналтын цамхаг;
- Хөдөлгөөн хязгаарлагч /лабиринт/;
- Хөдөлгөөн сааруулагч, тольдуур, шалгах тавцан, галын булан, нүхэн яам.

Хамгаалалтын хүч, хэрэгсэлд:

- Хорих ангийн харуул хамгаалалтын болон бусад мэргэжлийн ажилтнууд;
- Галт зэвсэг, тусгай хэрэгсэл;
- Хамгаалалтын бүс;
- Тээврийн хэрэгсэл;
- Албаны нохой;
- Болзошгүй ажиллагааны үед ажиллах төлөвлөгөө болон хуулийн дагуу явуулж буй бусад ажиллагаа.

Хамгаалалтын техник хэрэгсэлд:

- Телекамер, телехяналт
- Цахилгаан, дохиолол бүхий сийрэгжүүлсэн хөрстэй бүс
- Дотоодын хориотой бүс
- Гэрэлтүүлэх хэрэгсэл, тэдгээрийн удирдлагын төхөөрөмж
- Тэжээлийн кабель, цахилгааны утас зэргээс бүрдэнэ.

Монгол Улсын хэмжээнд 2017 оны байдлаар хорих анги, байгууллагад тусгай, баримтжуулах, хамгаалах, холбоо болон сургалтын хэрэгслийг харуул хамгаалалтын үйл ажиллагаанд ашиглаж байна.

Хорих байгууллагад мөрдөгдөх дэглэм журмыг сахиулах, цагийн хуваарийг биелүүлэх албан үүргээ гүйцэтгэхдээ бусдын хөдөлгөөнийг хорих, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, эсэргүүцэл, довтолгооныг таслан зогсоох зорилгоор тодорхой нэг хоригдол, яллагдагч халдан довтолсон этгээдэд хэрэглэж буй

тусгай хэрэгсэл, захиргааны шаардлагад нийтээрээ захирагдахгүй болж эмх замбараагүй байдал үүссэн, нийтийг хамарсан шинжтэй хууль бус үйлдлийг таслан зогсоох зорилгоор хэрэглэж буй 2 ба түүнээс дээш хүнд нэгэн зэрэг нөлөөлөх тусгай хэрэгсэл гэж үздэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, байгууллагуудын харуул хамгаалалтад дараах тусгай, хамгаалах болон баримтжуулах хэрэгслийг ашиглаж байна.

Иргэдийн дунд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага тэр дундаа хорих ял эдлүүлэх ажиллагааны талаар буруу ойлголттой байдагт судлаачийн зүгээс шүүмжлэлтэй ханддаг. Тухайлбал, нийт хорих ял эдлэгсдийг насанд хүрсэн хүн амын тоотой харьцуулж үзвэл 100.000 хүнд 220 хоригдол ноогдож байгаа нь бүс нутгийн хэмжээнд өндөр үзүүлэлт юм.

Мөн хорих ял эдлүүлэх ажиллагааг өнөөгийн эрүүгийн нөхцөл байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэлбэр, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох шаардлага үүсч байна. Тухайлбал, сүүлийн жилүүдэд авлига, албан тушаал, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, хүний амь нас, эрүүл мэндэд хүч хэрэглэн халдсан гэмт хэрэг үйлдэгсдийн тоо эрс өсч дийлэнх хувь нь хорих ялаар шийтгүүлж байна.

Сүүлийн 3 жилийн статистик тоо, дүн мэдээллээс үзвэл нээлттэй дэглэмд ял эдэлж буй хоригдлын тоо жилд дунджаар 550-аар нэмэгдэж байна. Харин 2017 онд УИХ-аар батлагдсан Эрүүгийн хууль тогтоомж хэрэгжиж эхэлсэнээс хойшхи хугацаанд нээлттэй дэглэмд ял шийтгэгдсэн хоригдлын тоо 1363-р буюу 1,02 дахин өсч, нийт хорих байгууллагын хэмжээнд хорих ангийн ачаалал нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлж байна¹.

“Эрүүгийн хууль” болон “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль” шинэчлэн батлагдсан 2017 оноос цагдан хоригдогсдын тоо 1100-аас 1500 болж 40 хувиар өсч, баривчлах шийтгэлээр шийтгүүлсэн хүний тоо 120-400 болж 2,3 дахин нэмэгдсэн байна^{1 2}.

Дээрх хоригдогсдын тоо эрс нэмэгдсэнээс үүдэн хорих байгууллагын хэмжээнд үүрэг гүйцэтгэж буй хамгаалалтын ажилтан,

¹ Сүлд инфо сэтгүүл - тусгай дугаар, 2019, УБ

² “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын орон тооны хүрэлцээ, алба хаагчийн ажлын ачааллын талаарх судалгаа, танилцуулга”. 2020. УБ.

холбоочин, дүрс бичлэгийн ажилтан зэрэг хоногийн харуул хамгаалалтад аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий алба хаагчид 24 цагийн үүрэг гүйцэтгэж, 48 цаг амарч байгаа нь Хөдөлмөрийн хуульд заасан ажил амралтын цагийн зохицуулалтыг зөрчихийн зэрэгцээ, ажлын ачааллыг эрс нэмэгдүүлэн алба хаагчийн эрүүл мэнд, аюулгүй байдалд өндөр эрсдэлийг үүсгэн, алба хаагчийн эрх зөрчигдөх, хорих анги, байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагаварыг үүсгэж байна¹.

Хорих байгууллагын харуул хамгаалалт, аюулгүй байдлын алба нь хоригдогч, хоригдлыг оргон зайлах, хорих ангийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулж болохуйцаар эмх замбараагүй байдал бий болгох, өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах зэрэг гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Дээрх гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсооход харуул хамгаалалт, аюулгүй байдлын үйл ажиллагааг хүний хүч, техник хэрэгслийг хослуулан зохион байгуулах нь үр дүнтэй байдаг.

Өнөөдөр Монгол Улсын хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагааг гадна болон дотоодын хамгаалалт гэж ерөнхийд нь ангилан зохион байгуулж байна.

2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, түүнд нийцүүлэн баталсан “Хорих ангийн харуул хамгаалалтын журам”²-д гадна хамгаалалтын инженерийн байгууламжийг гадна хориотой бүс, хамгаалалтын хашаа, дулаан, хөдөлгөөн мэдрэх дохиолол, цахилгаан хүчдэлийн шугам, дүрс бичлэгийн хяналт бүхий зурвас, нэвтрэх хэсгийн дуу-дүрсний бичлэгийн хяналт бүхий бүстэй байхаар тогтоож, гадна хориотой бүсийг хот суурин газарт хамгаалалтын хашаанаас гадагш 500 метр, орон нутагт 1000 метр зайд байхаар хуульчилсан.

Хорих ангиудын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, болзошгүй эрсдлийн үед шуурхай удирдлагаар хангах зорилгоор

¹ Мөн тэнд.

² Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/197 дугаар тушаал батлагдсан “Хорих ангийн харуул хамгаалалтын журам”

Шуурхай удирдлага, хяналтын төвийг байгуулан хорих анги, байгууллагуудыг дүрсний бичлэг, дохиоллын нэгдсэн системд холбосон нь харуул хамгаалалтын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулахад чухал ач холбогдолтой болсон.

Өнгөрсөн хугацаанд албан үүргээ гүйцэтгэж байгаад халдлагад өртөж амь насаа алдсан 10 алба хаагч байгаа бол, сүүлийн 10 жилийн байдлаар хорих байгууллагын алба хаагчийн биед халдсан 416 зөрчил, жилд дунджаар 50 шийдвэр гүйцэтгэгч халдлагад өртсөн тоо мэдээ байгаа ба сүүлийн 3 жилийн хугацаанд байгууллагын алба хаагчийн ажлын байр эрсдэл өндөртэй, хоригдол, хоригдогч, төлбөр төлөгчийн зүгээс үзүүлэх дарамт, сүрдүүлэг, заналхийлэл, ажлын ачаалал зэргээс шалтгаалан 330 алба хаагч өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн байна¹.

Энэ нь харуул хамгаалалтын үйл ажиллагаанд дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, ашиглалтыг сайжруулах хэрэгцээ шаардлага нэгэнт бий болсоныг бүрэн харуулж байна.

Харуул хамгаалалтын биечилсэн хяналт, хамгаалалтын ажилтны өдөр тутмын үйл ажиллагаа болон хамгаалалтад ашиглаж буй техник хэрэгсэлд тавих шалгуур үзүүлэлтийг үе шаттайгаар нэгдсэн стандартад оруулснаар зохих үр дүнгээ өгч байгаа хэдий ч тодорхой хүндрэл бэрхшээл тулгарсаар байна. Тухайлбал,

- Монгол Улс нь 1.6 сая хавтгай дөрвөлжин километр буюу өргөн уудам газар нутагтай бөгөөд өнөөдрийн байдлаар улс орны технологийн хөгжлөөс шалтгаалан үүрэн холбоо, интернетийн хүрэлцээ, хурд тэр бүр хангалттай хэмжээнд хүрээгүй нь улс орны тодорхой газар нутагт байршиж буй хорих ангиудын харуул хамгаалалтын технологийн хөгжилд шууд нөлөөлж байна.

- Байгаль, цаг уурын эрс тэс уур амьсгал бүхий өвөрмөц нөхцөлд байдгаас харуул хамгаалалтад ашиглаж буй техник нь дулааны улиралд цөлийн +30, хүйтний улиралд -40 хэмд ажиллах шаардлага тулгардаг нь техникийн ашиглалтад сөргөөр нөлөөлж, эвдрэл, гэмтэл дагуулдаг.

- Улсын хэмжээнд 2006 оныг 2020 онтой харьцуулахад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг

¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн талаарх судалгаа. 2021. УБ

32 дахин, холбогдсон этгээдүүд 12 дахин өссөн ба дээрх төрлийн бодисыг хорих ангийн байршилд нэвтрүүлэх санаа зорилго бүхий оролдлого гарч эхэлсэн¹ тул мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг таньж, илрүүлэх төхөөрөмжийг харуул хамгаалалтад нэвтрүүлэх зайлшгүй шаардлага урган гарч байгаа юм.

Сүүлийн жилүүдэд гадаадын орны хорих анги, байгууллагуудад хөдөлгөөнт утас /гар утас/ хорих ангид нэвтрүүлэх, ашиглах зөрчлүүд түгээмэл илрэх болсон. Харин манай улсын хувьд хорих байгууллагуудад дээрх зөрчил гаргахаас урьдчилсан сэргийлэх зорилгоор сүлжээ унагаагч төхөөрөмжийг Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийт хорих ангиудад нэвтрүүлсэн.

Энэ зөрчлийг таслан зогсоодог ч хоригдлын хувийн онцлог, засрал хүмүүжлийг нь харгалзан утсан харилцаагаар харилцах эрхийг нэмэгдүүлэх, зарим тохиолдолд урамшуулал хэлбэрээр олгодог болсон нь техник, технологийг эрх зүйн зохицуулалттай уялдуулан цогц байдлаар шийдвэрлэх арга замыг эрэлхийлсэнтэй холбон үзэж болно.

Гэвч дэлхий нийтэд өрнөж буй техник технологийн хурдацтай хөгжилд нийцүүлэн хорих ангийн харуул хамгаалалтад ашиглаж буй техник хэрэгслийг тухай бүр шинэчлэн сайжруулах шаардлагатай байна.

Хорих ангийн харуул хамгаалалтын техник хариуцсан мэргэшсэн ажилтныг бэлтгэх тогтолцоог хөгжүүлэх, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх шаардлага ч урган гарч байна.

Харуул хамгаалалтын үйл ажиллагаанд техник технологийг ашиглах нь зайлшгүй боловч алба хаагчийн биечилсэн хамгаалалтын чанар, үр дүнг орхигдуулж болохгүй юм.

Харуул хамгаалалт нь “Биечилсэн хяналтад дэмжлэг үзүүлэх хэрэгсэл нь техник юм” гэсэн үндсэн агуулгын хүрээнд зохион байгуулагдах ба алба хаагчийн үйл ажиллагааг хөнгөвчлөх, туслалцаа үзүүлэхэд чиглэгдсэн байдлаар хийгдэх учиртай юм.

Судлаачийн зүгээс Монгол Улсын хорих байгууллагад ашиглаж буй харуул хамгаалалтын техник технологийг орчин үеийн

¹ Хорих ял эдлүүлэх албаны 2020 оны үйл ажиллагааны тайлан

технологийн дэвшилтэй нийцүүлэх чиглэлээр дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаанд орчин үеийн техник, хэрэгслийг нэвтрүүлэх, түүнийг хөгжүүлэх чиглэлээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хууль тогтоомж болон стратеги төлөвлөлт, бодлогын баримт бичигт тусгаж өгөх. Тухайлбал,

харуул хамгаалалтын үйл ажиллагаанд орчин үеийн техник, хэрэгслийг нэвтрүүлэх хөгжлийн урт болон дунд хугацааны стратеги хөтөлбөрийг боловсруулах;

хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагааны техник хэрэгсэлд тавигдах шаардлага, стандарт, түүнийг шинэчлэх хугацаа зэргийн томъёолон хуульчлах замаар эрх зүйн орчныг бүрдүүлэх;

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын захиалгаар гадаадын болон дотоодын их, дээд сургуулиудад техник, технологийн чиглэлээр алба хаагчдын сурган бэлтгэж, хүний нөөцийг бүрдүүлэх;

- Хорих ялаар шийтгэгдсэн хоригдол, цагдан хоригдсон, баривчлагдсан этгээдэд хяналт тавих харуул хамгаалалтын техник хэрэгслийг ялгамжтай байдлаар нэвтрүүлэх удирдлага зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгох;

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага тэр дундаа хорих байгууллагын алба хаагчийн аюулгүй байдалд чиглэсэн эрсдэлт нөхцөл байдал нэмэгдэж байгаатай холбогдуулан алба хаагчийн мэргэжлийн үйл ажиллагаа, түүний онцлогт тохирсон техник хэрэгслийг нэвтрүүлэн ашиглах;

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа хорих байгууллагуудаас нэг хорих байгууллагыг сонгон авч туршилтын хугацаанд орчин үеийн техник, технологид суурилсан харуул хамгаалалт бүхий жишиг “Ухаалаг хорих анги” болгон өөрчилж үр дүнг тооцох, бусад хорих байгууллагуудад үе шаттайгаар нэвтрүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авах;

- Өнөөдрийн байдлаар улс орны технологийн хөгжлөөс шалтгаалан үүрэн холбоо, интернетийн хүрэлцээ, хурд тэр бүр хангалттай хэмжээнд хүрээгүй нь улс орны тодорхой газар нутагт

байршиж буй хорих ангиудын харуул хамгаалалтын технологийн хөгжилд шууд нөлөөлж байгаа тул орон нутгийн тэр дундаа алслагдсан аймаг, сумдад үйл ажиллагаа явуулж буй хорих байгууллагын дэд бүтэц, инженерийн байгууламжийг үе шаттайгаар хөгжүүлэх;

- Сүүлийн жилүүдэд хоригдогсдын эрхийг хангах асуудал эрчимтэй яригдаж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас түүний хэрэгжилтийг хангаж байгаа ч, алба хаагчдын ажлын ачааллаас шалтгаалж эрх зүйн байдал орхигдох нөхцөл байдал үүсч байгааг харуул хамгаалалтын үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийн шийдлийг цогц байдлаар нэвтрүүлэх шаардлагатай байна.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2017 он
2. Хорих ангийн харуул хамгаалалтын журам. УБ., 2017 он
3. Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг байгууллагуудын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө. УБ., 2021 он.
4. Д.Дамдинцэрэн. Монгол Улсын хорих ял эдлүүлэх ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага. Сүлд инфо сэтгүүл - тусгай дугаар. УБ., 2019 он
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн талаарх судалгаа. УБ., 2021 он
6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын орон тооны хүрэлцээ, алба хаагчийн ажлын ачааллын талаарх судалгаа, танилцуулга. УБ., 2020 он.
7. Хорих ял эдлүүлэх албаны 2020 оны үйл ажиллагааны тайлан. УБ., 2020 он